| | | | | | <p>иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж амьдралд хүрэлцэж байгаа эсэх,</p> <ul style="list-style-type: none"> • Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний хөдөлмөр эрхлэлт болон төрөөс авч буй үйлчилгээний нөхцөл байдлыг үнэлэх, • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох нөхцөл байдал, • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон байрны нөхцөл, хүртээмж, • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо, • Хөгжлийн бэрхшээлтэй залуу гэр бүлийн амьдралын нөхцөл байдал, • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлийн хүчирхийлэл өртөж байгаа байдал, • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг тус тус судлах юм. <p>Гэвч төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар уг ажил зогсонги байдалд орсон.</p> <p>УИХ-ын гишүүн О.Саранчулууны санаачлагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарт судалгаа хийхээр төлөвлөгдсөн бөгөөд уг ажилд манай яам хамтран ажиллах юм.</p> <p>Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” ЗГ-ын тогтоолын төсөл боловсруулан яамдаас саналаа авч, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд энэхүү шинжилгээ хийх ажлыг тусгасан.</p> |
|--|--|--|--|--|---|

| | | | | | | |
|-------|---|--------------------------------------|-----------|---|----|---|
| 1.3.1 | Өрх, гэр бүлийн бүтэц, гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлтийг үндэслэн гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг сайжруулж, Гэр бүлийн тухай хуульд хамтран амьдрах хэлбэр, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгана. | Хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан эсэх | Тийм/үгүй | 0 | 1 | Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ХЗДХЯ-тай хамтран боловсруулсан бөгөөд тус хуулийн төслийн 21 дүгээр зүйлд гэрлэлттэй адилтгах харилцаа хэсэгт холбогдох зохицуулалтыг тусгасан. Хуулийн төслийг ХЗДХЯ-аас өргөн мэдүүлнэ. |
| 1.3.3 | Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт | Хувь | 0 | 27 | Гэр бүлд чиглэсэн сургалтын модуль, хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, агуулгыг нэгтгэн боловсруулах, гэр бүлийн явуулын үйлчилгээний агуулга, хүрээг тодорхойлох ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хийх ажлын удирдамжийг ГБХНХСайдын 2024 оны 10 дугаар сарын 17-ны А/38 дугаар тушаалаар батлуулсан. Ажлын хэсэг 10-р сарын 18, 25-ны өдрүүдэд хуралдаж, төлөвлөгөө, удирдамжийг хэлэлцэж, салбаруудад хийгдэж буй иргэд, олон нийтийн гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээний агуулгыг шинжилсэн. Гэр бүлийн боловсролын хураангуй буюу явуулын үйлчилгээнд зориулсан хувилбар, дэлгэрэнгүй буюу Гэр бүлийн хөгжлийн цогц төвүүдээр хүргэх сургалтын хөтөлбөрийн хувилбарыг төсөл байдлаар боловсруулж ажлын хэсгийн гишүүд чиглэл тус бүрийн дагуу сайжруулан боловсруулж байна. Мөн дээрх хураангуй болон дэлгэрэнгүй хувилбаруудад өсвөр үе, залуучуудын гэр бүлийн боловсрол, гэр бүл төлөвлөлтийн талаарх агуулгыг тусгахад НҮБХАС-тай хамтран ажиллаж байна. |

| | | | | | | |
|--------|--|---------------------------------|------|---|-----|--|
| 1.5.7 | Малчдыг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэлтийг сайжруулах, хохирогчийг хамгаалах үр дүнтэй тогтолцоо, арга зүйг бий болгоно. | Хүчирхийллийн илрүүлэлтийн хувь | Хувь | 0 | 100 | <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 32 журам, 1 стандартын хэрэгжилтийг анхан шатанд Хамтарсан баг, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтэс, МУГХУСАЗ салбар зөвлөл хамтран хэрэгжүүлдэг. Улсын хэмжээнд 760 Хамтарсан багийн 6008 гишүүд Монгол Улсын иргэдийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, холбон зуучлах үүргийг анхан шатанд гүйцэтгэдэг. Иймээс ХЗДХЯ-тай хамтран Хамтарсан багийн гишүүдэд зориулсан арга зүйн 12 цуврал гарын авлагыг боловсруулж, 21 аймаг, 9 дүүргийн Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулсан. Улсын хэмжээнд 39 нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байраар дамжуулан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан 7 төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд 2024 оны байдлаар нийт 4611 иргэн үйлчилгээ авснаас 3073 хүүхэд, 1538 насанд хүрэгч байна.</p> <p>Малчдыг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд Хамтарсан баг илрүүлж, холбон зуучлах үүргийн дагуу түр хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хүлээдэг. Мөн 2025 онд сум, хороо бүрд Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллаж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэлтийг сайжруулах чиг үүргийг давхар хэрэгжүүлэх юм.</p> |
| 1.5.12 | Нийслэл дэх Түр хамгаалах байрыг хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд | Төрөлжсөн хамгаалах байр | тоо | 0 | 4 | Нийслэл дэх Түр хамгаалах байрыг хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх |

| | | | | | | |
|-------|---|---------------------------------------|-----------|---|---|--|
| | болон эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрөлжүүлэн байгуулж, санхүүжилтийг хуулийн дагуу шийдвэрлэнэ. | | | | | чиглэлээр төрөлжүүлэн байгуулах бэлтгэл ажлын хүрээнд судалгаа хийж байна. |
| 2.1.1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, түүний хэрэгжилтэд жендэрийн дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргана. | Нийт ажиллагчид, насны бүлэг, хүйсээр | Тийм/үгүй | 0 | 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, түүний хэрэгжилтэд жендэрийн дүн шинжилгээг Сангийн яам, Дэлхийн банкттай хамтран 2022 онд гүйцэтгэсэн. |
| 2.1.3 | Төр, ТББ, хувийн хэвшилд дэх ажил эрхлэлтэд саад болж байгаа бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг арилгахад чиглэсэн Засгийн газар, Ажил олгогчдын мэргэжлийн холбоод, Үйлдвэрчний эвлэл, хэвлэл мэдээлэл, холбогдох олон улсын түншлэгчидтэй хамтын ажиллагааны платформ үүсгэж ажиллуулна. | Платформд нэгдсэн байгууллага | тоо | 0 | 2 | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны Улсын хэлэлцээрийн 4.2-т “Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай тэмцэх чиглэлээрх хуулийн хэрэгжилтийг сайжруулах, олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн түншлэгч талууд идэвхтэй хамтран ажиллана” гэж тусгасан. Уг заалтын дагуу аж ахуйн нэгж, байгууллага, ажилтнуудад сургалт суртачилгааны ажлууд, гарын авлага, материал болон бодлого, хөтөлбөрийг боловсруулж, сайн туршлагыг түгээх ажлуудыг Засгийн газар, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоод хамтран ажиллаж байна. |
| 2.1.4 | Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг | Хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ | тоо | 0 | 1 | Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн үлгэрчилсэн зааврыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний |

| | | | | | | |
|-------|---|--|------------|---|----|---|
| | шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн үлгэрчилсэн зааврын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | | | | | хороо, Хүний эрхийн комисстой хамтран 2021 онд баталсан. |
| 2.1.5 | Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлого, төлөвлөлтийг баталж, хэрэгжүүлнэ. | Бодлого төлөвлөлт, хэрэгжилт | Хувь | 0 | 23 | Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох чиглэлээр Хөдөлмөрийн тухай хуульд дараах зохицуулалт тусгагдсан. 137 дугаар зүйл.Жирэмсний болон амаржсаны амралт, эцгийн чөлөө 136 дугаар зүйл.Хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлага, олговор олгох 141.1.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтныг өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулахыг хориглоно. Дээрх зохицуулалтын хэрэгжилтийг хангаж, төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-ууд хөдөлмөрийн дотоод журамдаа тусган хэрэгжүүлэх боломжтой. |
| 2.1.8 | Гэрийн хөлсгүй хөдөлмөрийг үнэлэх үнэлгээний арга зүйг нэвтрүүлж, үндэсний тооцооны системд тусгана. | Аргачлал үзүүлэлт баталж, нэвтрүүлсэн эсэх | Тийм/ үгүй | 0 | 1 | Статистикийн тухай хуулиар цаг ашиглалтын түүвэр судалгааг 4 жил тутам зохион байгуулахаар заасны дагуу 2023 онд мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулсан. 2024 онд судалгааны үр дүнг боловсруулан гаргаж, “Цалин хөлсгүй гэрийн ажил, асаргаанд зарцуулсан хугацаа, хүйсээр, насаар, байршлаар” тооцон гаргаж нийтэд тархаасан. Асрах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн |

| | | | | | | |
|--------|---|---|------|---|----|---|
| | | | | | | төсөл боловсруулах ажлын хэсэг УИХ-ын даргын 2024 оноос 100 дугаар захирамжаар байгуулагдсан. уг ажлын хэсэгт судалгаа, дүгнэлт, санал боловсруулаха хүрээнд ГБХНХЯ хамтран ажиллана. |
| 2.1.11 | Хүүхэд асрах үйлчилгээний зардлыг ач, зээгээ асарч буй ахмад настанд олгох зэрэг арга хэмжээг судалж шийдвэрлэнэ. | Үйлчилгээн ий төрөл, зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ахмад настан хүйсээр | Хувь | 0 | 11 | <p>Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэнд нийгмийн халамжийн сангаас сар бүр асаргааны тэтгэмж олгодог бөгөөд уг үйлчилгээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 2060 иргэн хамрагдаж, 4.7 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангаас олгожээ.</p> <p>ЗҮГАХ-ын 2.1.1.8-д “Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтална.” заасны дагуу Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлд хүүхэд асарсны тэтгэмжийг олон улсын туршлага, гадаад дотоодын судалгааны дүгнэлтэд үндэслэн шинэчлэхээр ажиллаж байна.</p> |
| 2.1.12 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгоно. | Бодлого арга хэмжээний хэрэгжилт | Хувь | 0 | 12 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-г Хөдөлмөр эрхэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрт 26 төрлийн үйл ажиллагаа багтсан бөгөөд 2024 оны 11 сарын байдлаар 2546 хүн хамрагдаж 7,5 тэрбум төгрөгийг ХЭДС-аас зарцуулсан байна. |

| | | | | | | |
|-------|--|------------------------------------|-----|---|----|--|
| 2.2.1 | Ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бий болгоно. | Хөшүүрэг, аж ахуйн нэгжийн төрлөөр | Тоо | 0 | 2 | Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газраас Зохистой хөдөлмөрийн талаар баримталж буй бодлого, Тогтвортой хөгжлийн зорилт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Жендэрийн бодлого төлөвлөлтөд баримталж буй эмэгтэй, эрэгтэй хүмүүст тулгарч буй бэрхшээлийн ялгаатай байдал, түүнээс үүдэн гарах жендэрийн ялгаатай эрэлт хэрэгцээг хангах; эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд үүсэн гарч буй асуудлыг жендэрийн хандлага талаас нь авч үзэх, хэрэгжүүлэх мэдлэг ойлголт, туршлагыг үндэсний түвшинд боловсронгуй болгох, сайжруулах зорилгоор “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого”-ыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 38 дугаар тогтоолоор батлуулсан. Дээрх бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд ЖҮХАА-наас МАОЭНХ-той хамтран үндэсний компаниуд, ажил олгогчдод зориулсан 3 удаагийн сургалт зохион байгуулсан. |
| 2.2.2 | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын жендэрийн агуулга, үр нөлөөг сурталчлан дэмжинэ. | Хамрагдсан байгууллагаа | Тоо | 0 | 21 | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг аймаг, нийслэл, салбарын холбоодод танилцуулах сургалтыг 13 аймаг, 9 сумын 1000 гаруй хүнийг хамгуулан зохион байгуулав . Мөн ЕБС-ын бүх анхан шатны хороод, Монголын орон сууц, нийгмийн аж ахуйн үйлчилгээний ажилтны 25 анхан шатны хороонд уг сургалтыг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран зохион байгуулав. |
| 2.2.4 | Сонгосон салбар дахь ажлын байрны орчин нөхцөл, хөдөлмөрийн | Үнэлгээ, сайн туршлага | Тоо | 0 | 2 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үйл |

| | | | | | | |
|-------|--|---------------|-----|---|---|---|
| | <p>аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд жөндөрийн үнэлгээ хийж, сайн туршлага гаргаж сурталчилна.</p> | | | | | <p>ажиллагааны хүрээнд Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгч ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд бүртгэлтэй MNS ISO 17020 стандартын итгэмжлэлтэй, дараах 6 байгууллага ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 2. Хэлт инспекшн ХХК 3. Дабльо эйч эй ХХК 4. Түмэн тэрэм ХХК 5. Хэлт сэфти энд фрий воркплейсэс ХХК 6. Эв их глюк ХХК <p>Дээрх байгууллагууд 2024 оны 06 сарын 01-ний байдлаар 120 аж ахуйн нэгж, байгууллагын 2684 ажлын байранд хэмжилт үнэлгээ хийж, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах тухай зөвлөмжийг хүргүүлсэн.</p> |
| 2.2.5 | <p>Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжих сайн туршлага гаргаж сурталчилна.</p> | Сайн туршлага | Тоо | 0 | 2 | <p>Эмэгтэйчүүдийн гэрээс, зайнаас болон цахимаар ажиллах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр хөдөлмөрийн харилцааны талаарх мэдлэг олгох, мэргэжлийн, суурь болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалтын арга хэмжээнд 935 иргэнийг хамрагдаж, 225 иргэнийг ажлын байраар хангагдаж, ХЭДС-аас 173.5 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>2025 онд дээрх арга хэмжээг өргөтгөн зохион байгуулах, мөн хүүхэд харах, асрах шалтгааны улмаас ажлын туршлага нь тасалдаж урт хугацаанд ажилгүй байсан</p> |

| | | | | | | |
|-------|--|---|------|---|----|--|
| | | | | | | иргэн, бага насны хүүхдээ асарч байгаа цагийн ажил хийх хүсэлтэй, боломжтой эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. |
| 2.2.8 | Төрийн үйлчилгээний байгууллагад харилцааны соёл, сэтгэлзүйн туслалцааг жөндөрийн мэдрэмжтэй нэвтрүүлнэ. | Сэтгэл зүйн үйлчилгээтэй байгууллага, салбараар | Тоо | 0 | 12 | “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандарт”-ыг ГБХНХСайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар батлуулсан. Үйлчилгээний стандартад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан үйлчилгээний төрөл тус бүрээр стандартын зохицуулалтуудыг нарийвчлан оруулсан бөгөөд стандартыг боловсруулахдаа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага MNS 6620:2016, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх заавар, аргачлал, улс орнуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх гарын авлага, зааварчилгаа , тус яаманд гадаад улсын санхүүжилтээр хэрэгжиж байсан олон улсын төслүүдийн санал, зөвлөмж болон бусад холбогдох баримт бичгүүдийг судлан боловсруулсан болно. |
| 2.2.9 | Ажилтныг байгууллагаас унаагаар хангахад шаардагдах үзүүлэлтийг гаргаж, хамтын гэрээнд тусгана. | Үзүүлэлт, тусгасан хамтын гэрээ | Хувь | 0 | 5 | Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.7-д "хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах , хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд |

| | | | | | | |
|--------|--|---|-----------|---|---|--|
| | | | | | | байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог хэлнэ гэж заасан. Хуульд заасны дагуу төрийн болон хувийн хэвшлийн байгууллага дээрх заалтын дагуу ажилтныг илүү таатай, аюулгүй орчноор хангах эрх зүйн орчин бүрдсэн. |
| 2.2.11 | Гадаадад ажиллах гэрээт ажилчдын гэр бүлийн хамтын амьдралыг дэмжсэн эрх зүйн орчныг бий болгоно. | Туршилтын хөтөлбөр хэрэгжүүлсэн эсэх | Тийм/үгүй | 0 | 1 | Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулан ажиллаж байна. Санамж бичгийг шинэчлэн байгуулах хүрээнд БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй гэрээт ажилчид шалгуур хангасан тохиолдолд гэр бүлээр нь ажиллуулах талаар харилцан зөвшилцөж шийдвэрлэх талаар санал хүргүүлсэн боловч БНСУ-ын тал саналыг хүлээн аваагүй болно. |
| 2.3.1 | Үндэсний тооцооны системийн үзүүлэлт, түүний дотор орлогын аргаар тооцсон ДНБ, нөөц ашиглалтын талаарх жендэрийн статистикийн үзүүлэлтийг нэвтрүүлж, дүн шинжилгээнд ашиглана. | Жендэрийн статистик үзүүлэлтийг ашигласан дүн шинжилгээ | Тоо | - | 1 | ҮСХ-ны чиг үүрэгтэй илүү уялдах тул ҮСХ манлайлан ажиллах саналтай байна. |
| 2.3.4 | Салбар дахь болон салбар хоорондын ажлын үнэлгээ, нийгмийн хувь нэмрийг үнэлэхэд тэгш | Судалгаа | Тоо | 0 | 1 | Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолоор Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар байгуулагдан, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулагдсан. |

| | | | | | | |
|--------|---|--------------------------------|-----------|------|------|--|
| | шударга хандлага тогтоох чиглэлээр үндэсний болон олон улсын түвшний харьцуулсан судалгаа хийнэ. | | | | | Уг үйл ажиллагаа нь ЗГХХГ-ын чиг үүрэгтэй илүү уялдах тул тус байгууллагаас хэрэгжилтийн тайлан тус байгууллагад хандан авах саналтай байна. |
| 2.3.10 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай арга хэмжээ, зохицуулалт нэмж тусгана. | Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх | Тийм/үгүй | Үгүй | 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх зорилгын хүрээнд холбогдох зохицуулалтыг оруулах асуудлыг судалж байгаа болно. |
| 2.3.11 | Эмэгтэй хэв шинжийн бизнесийг тодорхойлж, дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх | Тийм/үгүй | Үгүй | Тийм | <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан” Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр” –ийн дагуу 2024 онд Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн санхүүжилтээр 13,000,000,000 төгрөгийн эх үүсвэрийг Хаан болон Төрийн банканд байршуулан жижиг зээл олгох арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>Улсын хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Аймаг дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нийт 1078 төслийн хүсэлтийг хүлээн авч, шаардлага хангасан 1078 төслийг зээл олгож болох эсэхийг судлуулахаар банканд хүргүүлсэн байна.</p> <p>Үүнээс банкны шаардлага хангасан 561 төсөлд 13.2 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.</p> |

| | | | | | | |
|--------|--|---|-----------|------|------|--|
| 2.3.13 | "Ижил үнэ цэнтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчим хэрэгжүүлэх аргачлал"-ыг жендэрийн мэдрэмжтэй нэвтрүүлнэ. | Хэрэгжилт | Хувь | 0 | 20 | Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.1-т "ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх" гэж тус тус заасан. Дээрх хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаанд эмэгтэй, эрэгтэй хүний эрх тэгш байх зарчмыг баримтлан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 02 дугаар тогтоолоор "Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал"-ыг батлан хэрэгжүүлж байна. |
| 2.4.1 | КОВИД-19 цар тахлын болон дараах үеийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдалд нарийвчилсан судалгаа хийж, зөвлөмж гаргана. | Судалгаа хийгдэж, зөвлөмж хүргэгдсэн эсэх | Тийм/үгүй | Үгүй | Тийм | <p>ГБХНХЯ-ны харьяа Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээл дэх "COVID-19" цах тахлын нөлөө судалгааг 2020, 2021 онд улирлаар гаргаж олон нийтэд нээлттэй байршуулсан. http://institute.gov.mn/web/research</p> <p>Монгол Улсын хувьд цар тахлын хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх ихэвчлэн түүвэр судалгааны аргаар Азийн сан (2021), ҮСХ болон Дэлхийн банк (2020), ОУХБ (2020), Монголбанк (2021) шинжилжээ хийсэн.</p> <p>Азийн сан (2021) судалгаанд цар тахлын тархалтыг хумих хүрээнд авч хэрэгжүүлсэн бодлого арга, хэмжээний тэгш бус байдал, тэр дундаа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийг судалсан бөгөөд голлох үр дүнг тоймлон дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> Цар тахал бүртгэгдсэн үе буюу 2020 оны нэгдүгээр сарын байдлаар Монгол Улсын нийт өрхийн 73 хувь, бага орлоготой |

| | | | | | | |
|-------|---|---|---------------------------|---------------|-----------------|---|
| | | | | | | <p>өрхийн 85 хувь цар тахал, хөл хориотой холбоотой ямар нэг хүндрэлд өртсөн бөгөөд хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, бизнесүүд хаалгаа барьж, ажилгүй иргэдийн тоо нэмэгдэж байна,</p> <ul style="list-style-type: none"> • Эдийн засагт үзүүлэх нөлөөллийн хувьд эмэгтэйчүүд давамгайл ажилладаг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний 50-иас дээш хувь нь цар тахлаас шалтгаалан үйл ажиллагаагаа зогсоох эрсдэлтэй тулгарсан, • Зочлох үйлчилгээ, аялал жуулчлал зэрэг эмэгтэй ажиллах хүч ихтэй салбаруудын хувьд цар тахлын сөрөг нөлөө илүү өндөр байна. |
| 2.4.5 | Эрсдэлтэй/гамшгийн нөхцөлд тэргүүн шугамд ажиллагчдын ажлын орчин нөхцөлд жендэрийн шинжилгээ хийж, шинэ хэвийн нөхцөлд нийцүүлэх удирдамжийг жендэрийн мэдрэмжтэй гаргаж нэвтрүүлнэ. | Удирдамж нэвтрүүлсэн эсэх Удирдамжийг нэвтрүүлж, сургалтын тогтолцоотой болсон байгууллага | Тийм/ үгүй Хувь | Үгүй 0 | Тийм 100 | 2024 оны байдлаар ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийж буй итгэмжлэл бүхий 6 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагуудаар энэ онд 275 аж ахуйн нэгж байгууллагын 4686 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийгдсэнээс 32 хувь нь хэвийн бус нөхцөлөөр үнэлэгдсэн байна. Цаашид эрсдэл, гамшгийн нөхцөлд ажиллагчдын ажлын нөхцөлд жендэрийн шинжилгээ хийхээр төлөвлөж байна. |
| 5.1.8 | Ногоон ажлын байрны шалгуур үзүүлэлтийг салбар бүрт жендэрийн мэдрэмжтэй боловсруулж нэвтрүүлнэ. | Шалгуур үзүүлэлт нэвтрүүлсэн салбар | Хувь | 0 | 70 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөр/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр |

| | | | | | | |
|-------|---|--|------|---|----|---|
| | | | | | | <p>эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамжийн дагуу хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлсээр ирсэн.</p> <p>Тухайлбал, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Мод тарих, ногоон ажлын байрыг бий болгох, мод нийлүүлэх ажлыг мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага, иргэдийн бүлгийн гишүүдийг сургах, нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнийг түлхүү хамруулах бөгөөд сум, хорооны бүртгэлтэй ажилгүй иргэдээс 2 болон түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй багуудыг хамруулна.</p> <p>2024 оны байдлаар тус арга хэмжээнд 2299 иргэн хамрагдаж, 798.6 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> |
| 5.2.3 | Мэргэшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад ногоон ур чадвар олгох агуулга, арга зүйг нэвтрүүлнэ. | Ногоон ур чадвар олгох агуулга, арга зүйг нэвтрүүлсэн сургалтын хөтөлбөр | Хувь | 0 | 60 | Уг арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. |

“Удирдах албан тушаалтанд зориулсан жөндөрийн цахим сургалт”-д
хамрагдсан адирдах албан хаагчдын мэдээлэл

| № | Яам, агентлагийн нэр | Овог, нэр, албан тушаал | Хүйс | Гэрчилгээний дугаар |
|----|--|--|------|---------------------|
| 1. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | - | - | - |
| 2. | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар | - | - | - |
| 3. | Нийгмийн даатгалын ерөнхий газар | - | - | - |
| 4. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар | - | - | - |
| 5. | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | - | - | - |
| 6. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв | Захиргаа удирдлагын газрын дарга- Жанчивламдан Рэнцэнбаяр | Эр | - |
| | | Сургалт, судалгаа мэдээлэл, хамтын ажиллагааны газрын дарга- Лхагвадорж Амартүвшин | Эр | - |
| | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн газрын дарга- Рагчаабазар Өлзий-Орших | Эр | - |
| | | Мэргэжлийн өвчин судлалын газрын дарга- Лхагважав Зоригт | Эр | - |
| | | Захиргааны хэлтсийн дарга- Дүүдээ Анхзаяа | Эм | - |

| | | | | |
|----|---|---|----|---|
| | | Сургалт судалгаа, бүртгэл мэдээллийн хэлтсийн дарга-Дуламжав Энхдөлгөөн | Эм | - |
| | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэлтсийн дарга-Пэрэнлэй Энхтайван | Эр | - |
| | | Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн хэлтсийн дарга-Алтангэрэл Цэнгэлмаа | Эм | - |
| 7. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт | - | - | - |

“Иргэд, олон нийтэд зориулсан жендэрийн цахим тест”-д хамрагдсан албан хаагчдын мэдээлэл

| № | Яам, агентлагийн нэр | Овог, нэр, албан тушаал | Хүйс |
|----|---|-------------------------|------|
| 1. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | - | - |
| 2. | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар | - | - |
| 3. | Нийгмийн даатгалын ерөнхий газар | - | - |
| 4. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар | - | - |
| 5. | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | - | - |
| 6. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв | - | - |
| 7. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт | - | - |